



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2024/04/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Дундговь аймаг

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох

Утас: 70592439

Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал

Утас: 70592225

Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр

Утас: 70593113

Цахим хаяг: ikhbayard@audit.gov.mn

Аудитор: Т.Оюун-Эрдэнэ

Утас: 70593113

Цахим хаяг: oyunerdenet@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭРДЭНЭДАЛАЙ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ЛХАГВАМАНДАЛ ТАНАА

2024-03-25 № 113

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын 203 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд татварын орлогын төлөвлөгөөг 28.1 хувиар, 7 нэр төрлийн орлогыг тасалж, татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөний биелэлтийн хангах ажлыг хангалтгүй хэрэгжүүлсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй. Мөн Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан төсөл хэрэгжүүлэгчид үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтрүүлснээс нийт 41,991.0 мянган төгрөгийн хохирол учруулжээ. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зураг төсөв, эдийн засгийн тооцоо судалгаа хийгдээгүй, магадлалаар баталгаажуулаагүй арга хэмжээнд зарцуулахаар

баталсан, нэмэлт гэрээ байгуулсан зэрэг зөрчил нь тайлант үеийн удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байлаа.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу 4 хөтөлбөр, 13 зорилт, 64 арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 93.5 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



P.МӨНХТОГТОХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,027,389.8	836,819.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	588,623.2	269,053.8
33	АВЛАГА	159,778.8	167,223.4
35	БАРАА МАТЕРИАЛ	136,787.9	240,342.1
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	142,200.0	160,200.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,715,836.4	3,544,386.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,715,836.4	3,544,386.2
39200	Биет хөрөнгө	2,661,309.5	3,483,502.3
39300	Биет бус хөрөнгө	54,527.0	60,884.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,743,226.3	4,381,205.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	52,306.6	49,856.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	52,306.6	49,856.9
41300	Өглөг	52,306.6	49,856.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,690,919.7	4,331,348.6
51	Засгийн газрын хувь оролцоо	3,690,919.7	4,331,348.6
51100	Засгийн газрын оруулсан капитал	855,826.9	855,826.9
51200	Хуримтлагдсан үр дүн	2,170,280.6	2,810,783.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	664,812.2	664,738.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,743,226.3	4,381,205.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,385,774.6	4,017,242.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	527,833.3	643,500.5
110	Орлогын албан татвар	271,323.9	359,420.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	271,323.9	359,420.3
113	Хөрөнгийн албан татвар	127,378.5	193,166.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	129,130.8	90,913.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	456,864.0	1,611,722.8
120	Нийтлэг татварын бус орлого	456,864.0	1,611,722.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,401,077.4	1,762,019.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,644,872.3	2,091,934.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,644,872.3	2,091,934.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,031,580.2	1,478,253.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	348,529.1	523,723.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,315.0	66,088.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,403.1	83,764.9
2104	Хангамж, бараа материалын зардал	61,148.1	69,335.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,715.0	46,512.0
2107	Томилолт, зочны зардал	4,745.0	19,088.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,013.7	30,268.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	481,711.3	639,471.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	613,292.1	613,681.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	740,902.4	1,925,307.9
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	0.0

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,536,183.9	1,305,834.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-6,795,281.6	619,473.8

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,752,784.3	10,752,784.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-266,583.1	-266,583.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,486,201.2	10,486,201.2
9	Тайлант үеийн үр дүн	-6,795,281.6	-6,795,281.6
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,690,919.7	3,690,919.7
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,690,919.7	3,690,919.7
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	21,028.9	21,028.9
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,711,948.6	3,711,948.6
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-73.8	-73.8
19	Тайлант үеийн үр дүн	619,473.8	619,473.8
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	4,331,348.6	4,331,348.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,031,782.2	2,608,670.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	527,833.3	643,500.5
110	Орлогын албан татвар	271,323.9	359,420.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	271,323.9	359,420.3
113	Хөрөнгийн албан татвар	127,378.5	193,166.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	129,130.8	90,913.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	9,701.4	6,255.4
1181	Газрын төлбөр	27,413.4	84,658.1
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	92,016.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	106,655.7	205,363.6
120	Нийтлэг татварын бус орлого	106,655.7	205,363.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,397,293.2	1,759,806.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,402,517.0	1,708,297.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,402,517.0	1,708,297.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,319,752.2	1,691,269.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	427,468.6	518,063.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,445.9	66,120.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	517,460.6	83,764.9
2104	Хангамж, бараа материалын зардал	46,450.4	69,606.7
2105	Нормативт зардал	0.0	2,650.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,200.0	46,512.0
2107	Томилолт, зочны зардал	4,745.0	19,088.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,459.8	624,709.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	221,521.9	260,754.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82,764.8	17,027.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	629,265.1	900,373.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	547,677.1	1,219,942.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	547,677.1	1,219,942.7

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2200	Догоод эх үүсвэрээр	547,677.1	1,219,942.7
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-547,677.1	-1,219,942.7
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	81,588.0	-319,569.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	507,035.2	588,623.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	588,623.2	269,053.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,480,610.4	2,881,407.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,842,989.3	1,661,592.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,828,539.3	1,647,650.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	534,305.0	518,063.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,149.5	66,120.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	651,279.0	636,320.0
2104	Хангамж, бараа материалын зардал	66,564.6	66,477.2
2105	Нормативт зардал	2,650.0	2,650.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	84,309.1	83,597.7
2107	Томилолт, зочны зардал	18,580.0	18,126.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,197.1	24,929.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	373,505.0	231,365.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,450.0	13,942.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,450.0	13,942.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,427,921.1	1,219,814.7
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	209,700.0	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,480,610.4	2,675,837.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	763,341.1	763,341.1
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,062,989.3	1,774,393.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	654,280.0	138,102.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	456,576.5
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	251,006.4

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	45,551.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	45,551.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	43,197.5
2104	Хангамж, бараа материалын зардал	3,257.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,800.0
2107	Томилолт, зочны зардал	962.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,339.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,838.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,354.2
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,354.2
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	45,551.7
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,551.7

3. Аудитын илрүүлэлт

3.1 Сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа:

Аудитаар нийт 279,710.6 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэнд албан шаардлага хүргүүлсэн.

3.1. Албан шаардлага

3.1.1 Тайлант хугацаанд мэдээлэх 21 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т */Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна/, 3.1.4-т /Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага/ 4 дүгээр зүйлийн /Шилэн дансны зарчим/ 4.1.3-т */тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх/* заасныг;*

3.1.2 Татварын орлогын төлөвлөгөөг 28.1 хувь буюу 279,710.6 мянган төгрөгөөр, 7 нэр төрлийн орлогыг тасалж, татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөний биелэлтийн хангах ажлыг хангалтгүй хэрэгжүүлсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй.

Энэ нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59.1.19-д */Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах/, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т /Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх/, 41 дүгээр зүйлийн 41.2-т /Бүх шатны төсөв захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ/, 41.2.1-т /Хуулийн дагуу, улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухай төсвийн байгууллагын үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх/, Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.30-д */татварын улсын байцаагч гэж энэ хуулийн дагуу татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлж, татвар төлөгчид үйлчлэх, татвар хураах, тайлан хүлээн авах, хяналт шалгалт хийх чиг үүрэг бүхий татварын албанд ажилладаг, эрх олгогдсон төрийн захиргааны албан хаагчийг/* заасныг тус тус зөрчсөн байна.*

3.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шүүд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг даргын Тамгын газар	1	1			1			
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Мал хамгаалах сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн	1		1					
6	Байгаль хамгаалах сан	1		1					
	НИЙТ	6	1	5		1			

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 234,054.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 45,869.7 мянган төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт тогтоож, 111,365.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 7 албан шаардлага, 63,189.0 мянган төгрөгийн 2 заалт зөвлөмжийг хүргүүллээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 62.3 хувийг залруулагдаагүй, 37.7 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

№	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Засаг даргын Тамгын газар	2	3,221.5	1	2,266.9	1	954.5	2	3,221.5				
2	Тусгай зориулалтын сан	1	10,400.0	1	10,400.0			1	10,400.0				
	Дүн	3	13,621.5	2	12,666.9	1	954.5	3	13,621.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс:									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Засаг даргын Тамгын газар	1	975.0			1	975.0						
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	2	3,318.7	1	618.7	1	2,700.0						
3	Тусгай зориулалтын сан	1	3,189.0					1	3,189.0				
	Нийт зөрчлийн дүн	4	7,482.7	1	618.7	1	3,675.0	1	3,189.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Засаг даргын Тамгын газар	1	-			1	-		
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1	-			1	-		
Дүн	2	-			2	-		
2. Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан								
Орон нутгийн хөгжлийн сан	2	127,299.5			1	67,299.5	1	60,000.00
Засаг даргын Тамгын газар	2	42,693.1	1	3,260.0	1	39,433.1		
Нэгтгэсэн санхүүгийн тайлан	1	279,710.6			1	279,710.6		
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	2	958.2			2	958.2		
Хоршоо хөгжүүлэх сан	5	41,991.0	5	41,991.0				
Дүн	12	450,661.4	6	3,260.0	5	387,401.4	1	60,000.00
Нийт дүн	14	492,652.4	6	45,251.0	7	387,401.4	1	60,000.00